



*Хяналт шалгалт, зохицуулалтын газар  
Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах чиглэл*

## 2023 ОНЫ ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот  
2023 он

## АГУУЛГА

### НЭГ. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА

1.1.1 Үнэт цаасны зах зээл.....	4
1.1.2 Даатгалын зах зээл .....	6
1.1.3 Банк бус санхүүгийн байгууллага .....	8
1.1.4 Хадгаламж, зээлийн хоршоо.....	10
1.1.5 Бусад	

### ХОЁР. АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БУСАД АРГА ХЭМЖЭЭ

#### ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Нийт өргөдлийн тоо .....	2
Хүснэгт 2. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдлийн товч утга.....	4
Хүснэгт 3. Даатгалын зах зээлтэй холбоотой өргөдлийн товч утга .....	6
Хүснэгт 4. Өргөдөл гомдолд эзлэх даатгалын бүтээгдэхүүний төрөл .....	7
Хүснэгт 5. ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн товч утга.....	8
Хүснэгт 6. ХЗХ-дын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн товч утга.....	10
Хүснэгт 7. Бусад өргөдлийн товч утга .....	10

#### ГРАФИК

График 1. Өргөдөл, гомдлын салбарын харьцуулалт.....	3
График 2. Өргөдлийн хэлбэр.....	3
График 3. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдлийн харьцуулалт.....	4
График 4. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдлийн хэлбэр.....	5
График 5. Даатгалын зах зээлтэй холбоотой өргөдлийн харьцуулалт.....	6
График 6. Даатгалтай холбоотой өргөдлийн хэлбэр.....	7
График 7. ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн харьцуулалт.....	9
График 8. ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн хэлбэр.....	9
График 9. ХЗХ-дын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн харьцуулалт.....	10
График 10. Бусад өргөдөл.....	11

## НЭГ. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо мөн хуулийн 3 дугаар зүйлд заасан хуулийн үйлчлэх хүрээнд хэрэгжүүлэн ажилладаг.

Дээрх чиг үүргийн дагуу хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч хянан, гомдлыг барагдуулах талаар санал дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх (1), зохих маргааныг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хянан шийдвэрлүүлэх (2), хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах (3), хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийг төлөөлж хууль, шүүхийн байгууллагад хандах, тэдний эрх ашгийг хуулийн хүрээнд хамгаалах (4), эрх ашиг нь зөрчигдсөн хөрөнгө оруулагчдын хохирлыг барагдуулах талаар хуулийн хүрээнд шаардлагатай арга хэмжээ авч ажиллах (5) зэрэг арга хэмжээг тус Хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар хариуцан гүйцэтгэж байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар иргэн, хуулийн этгээдээс нийт 1177 өргөдөл, гомдол ирүүлснийг хүлээн авч, 1153 өргөдөл, гомдлыг шийдвэрлэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан бол 24 өргөдөл хуулийн хугацаанд хянагдаж байна.

Үүнээс, албан бичгээр хандсан 636, цахим системээр хандсан 192, Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан ирүүлсэн 29, утсаар хандсан 320 иргэн, хуулийн этгээдэд тус тус хариу болон зөвлөгөө, мэдээллийг тухай бүр хүргүүлэн ажилласан.

Нийт ирүүлсэн (бичгээр, цахим системээр, 11-11 төвөөр дамжуулан, утсаар) өргөдөл, гомдлын тоо дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 1. Нийт өргөдлийн тоо

№	Салбар	2021	2022	2023						
				Албан бичиг	Info	Цахим	11-11 төв	Утас	Нийт	Эзлэх хувь
1	Даатгал	201	259	350	44	54	5	156	609	51.7%
2	Үнэт цаас	143	135	103	-	4	14	27	148	12.6%
3	ББСБ	84	140	140	15	9	8	102	274	23.3%
4	ХЗХ	21	20	10	-	4	-	4	18	1.5%
5	Бусад	26	77	33	3	59	2	31	128	10.9%
Нийт		475	631	636	62	130	29	320	1177	100%

Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын дийлэнх буюу 51,7 хувийг даатгалын үйлчилгээтэй холбоотой өргөдөл, гомдол эзэлж байна.

График 1. Өргөдөл, гомдлын салбарын харьцуулалт





График 2. Өргөдлийн хэлбэр



Хороонд 2023 оны байдлаар ирсэн нийт өргөдөл, гомдлын тоог өмнөх оны мөн энэ үетэй харьцуулахад 53,6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Шийдвэрлэлтийн явц, авах арга хэмжээний хүрээний ялгаатай байдлаас хамааран тухайн өргөдөл, гомдлыг хянан, шийдвэрлэх хугацаа харилцан адилгүй байгаа бөгөөд нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 17 хоног байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаанд Хороонд ирж буй дийлэнх өргөдөл, гомдлын утга, агуулга нь оролцогч талуудын хоорондын илүү төвөгтэй маргааны хэлбэртэй байдаг нь нөлөөлж буйгаас гадна зарим зөрчлийн шинжтэй өргөдөлд эрх бүхий албан тушаалтны зүгээс хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэлт хийж, прокурорын байгууллагаар хянуулах шаардлага үүсдэгтэй холбоотой.

### 1.1 Салбарын үзүүлэлтүүд

Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын хоорондын маргааныг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 33 дугаар зүйлийн 33.1, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.1 болон холбогдох бусад хууль тогтоомжийн зүйл, заалтад тус тус заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлж буй үнэт цаас, даатгал, банк санхүүгийн байгууллагын үйлчлүүлэгч, хадгаламж, зээлийн хоршооны гишүүд болон

иргэдээс Хороонд хандаж 2023 оны байдлаар ирүүлсэн өргөдөл, гомдлын талаарх мэдээллийг дор сийрүүлэв.

### 1.1.1 Үнэт цаасны зах зээл


Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон ХК-тай холбоотой нийт 148 өргөдөл, гомдол ирүүлснээс албан бичгээр хандсан 97, цахим системээр хандсан 4, Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан ирүүлсэн 14, утсаар хандсан 27 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн бол албан бичгээр ирсэн 6 өргөдөл, гомдол хуулийн хугацаанд хянагдаж байна.

Өргөдөл, гомдлыг товч утгаар нь ангилбал:

Хүснэгт 2. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой албан бичгээр ирсэн өргөдлийн товч утга


№	Товч утга	2021	Эзлэх хувь	2022	Эзлэх хувь	2023				
						Албан бичиг	Цахим	11-11 төв	Нийт	Эзлэх хувь
1	Хувьцаа зөвшөөрөлгүй арилжаалсан	40	28.0%	64	47.5%	60	-	-	60	49.6%
2	Хувьцааны бүртгэл, дансны мэдээллийг шалгуулах	20	14.0%	18	13.4%	23	-	7	30	24.8%
3	Хувьцааны тоо өөрчлөгдсөн	-	-	-	-	-	-	-	-	-
4	ХОЭБ	14	9.8%	10	7.4%	2	-	-	2	1.7%
5	Хамтын сан	6	4.2%	13	9.6%	3	-	-	3	2.5%
6	ҮЦК, ХК-ийн үйл ажиллагаа	57	39.8%	24	17.7%	5	-	-	5	4.1%
7	Бусад <sup>1</sup>	6	4.2%	6	4.4%	10	4	7	21	17.3%
Нийт		143	100%	135	100%	103	4	14	121	100%

График 3. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдлийн харьцуулалт



<sup>1</sup> “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцаа, МХБ-ийн IPO холбоотой өргөдөл, гомдол

График 4. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдлийн хэлбэр



Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг үндэслэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, “ҮЦТХТ” ХХК, үнэт цаасны компаниудаас баримт, тайлбар гаргуулан тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгчийн хооронд гарсан маргааныг урьдчилан шийдвэрлэж байна.

Тайлант хугацаанд үнэт цаастай холбоотой иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлуудаас хувьцааны бүртгэл данс шалгуулах тухай 24.8 хувь, хувьцааг харилцагчийн зөвшөөрөлгүй арилжсан 49.6 хувь, ҮЦК, ХК-ийн үйл ажиллагаатай холбоотой 4.1 хувь, хамтын сантай холбоотой өргөдөл 2.5 хувийг тус тус эзэлж байна. Энэ төрлийн өргөдлийн тоо өссөн шалтгаан нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хөрөнгө оруулалтын эрхийн бичиг, ягаан цэнхэр тасалбартай холбоотой мэдээллийг шалгуулах, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд харилцагчдын их хэмжээний мөнгө тараагдаагүй төвлөрч байна гэх мэдээлэлтэй холбогдуулан иргэдээс өмнө нь тухайн асуудлаар хандан Хорооноос албан бичгээр хариу өгсөн асуудлаар дахин хандах тохиолдлууд нэмэгдэж байгаатай холбоотой байна.

Харилцагчийн зөвшөөрөлгүйгээр хувьцаа арилжсантай холбоотой өргөдөл, гомдлоос хувьцаа худалдах, захиалгын гэрээ болон бэлэн мөнгө хүссэн өргөдөл, мөнгө олгосон тайланд нэр бүхий иргэний гарын үсэг зурагдсан гэх утгатай өргөдөл, гомдол багагүй хувийг эзэлдэг бөгөөд гарын үсэг зурагдсан бол тухайн гарын үсгийн хуурамч эсэхийг холбогдох эрх бүхий байгууллагаар тогтоолгох талаар зөвлөн ажиллаж байна. Мөн 2000 оноос өмнө тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон брокер, дилерийн компанийн холбогдох этгээд, тэдгээрийн талаарх бүртгэл, мэдээлэл байхгүй байгаа талаар, ХК-аас ногдол ашиг авахгүй байгаа болон татан буугдсан брокер, дилерийн компаниар дамжуулан арилжаалагдсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.20 дахь заалтыг буцаан хэрэглэх боломжгүй, гомдолд дурдсан асуудал нь тухайн үеийн хуулиар зөрчилд тооцогддоггүй байсан, зөрчлийн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн зэрэг шалтгааны улмаас зөрчлийн шинжгүй гэж үзэн гомдлыг хүлээн авахаас татгалзаж, уг асуудлаар хуулийн байгууллагад хандуулахаар урьдчилсан шийдвэр гаргасан тохиолдлууд багагүй хувийг эзэлж байна.

### 1.1.2 Даатгалын зах зээл

Тайлант хугацаанд даатгалын салбартай холбоотой нийт 609 өргөдөл, гомдол ирүүлснээс албан бичгээр хандсан 341, цахим системээр хандсан 98, Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан ирүүлсэн 5, утсаар хандсан 156 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн бол албан бичгээр ирсэн 9 өргөдөл, гомдол хуулийн хугацаанд хянагдаж байна.

Өргөдөл, гомдлыг товч утгаар нь ангилбал:

Хүснэгт 3. Даатгалын зах зээлтэй холбоотой албан бичгээр ирсэн өргөдлийн товч утга

№	Товч утга	2021	2022	2023				
				Албан бичиг	Цахим, Info	11-11 төв	Нийт	Эзлэх хувь
1	Нөхөн төлбөр олгохоос татгалзсан	133	157	199	15	-	214	47.2%
2	Нөхөн төлбөр олгохгүй удаасан	21	30	83	71	4	158	34.9%
3	Нөхөн төлбөрийг хасч олгосон	22	25	30	3	-	33	7.3%
4	Даатгалын хураамжийн маргаан	1	10	4	1	-	5	1.1%
5	Даатгалын хохирлын үнэлгээ болон бусад	24	35	34	8	1	43	9.5%
Нийт		201	257	350	98	5	453	100%

График 5. Даатгалын зах зээлтэй холбоотой өргөдлийн харьцуулалт





График 6. Даатгалтай холбоотой өргөдлийн хэлбэр



Тайлант хугацааны даатгалын өргөдөл, гомдлыг бүтээгдэхүүний төрлөөр нь ангилбал:

Хүснэгт 4. Өргөдөл гомдолд эзлэх даатгалын бүтээгдэхүүний төрөл

№	Даатгалын төрөл	2021	Эзлэх хувь	2022	Эзлэх хувь	2023				
						Албан бичиг	Цахим, info	11-11 төв	Нийт	Эзлэх хувь
1	Жолоочийн хариуцлагын даатгал	23	11.5%	53	20.6%	97	73	-	170	37.5%
2	Авто тээврийн хэрэгслийн даатгал	64	31.8%	110	42.8%	131	18	-	149	33.0%
3	Гэнэтийн ослын даатгал	64	31.8%	38	14.8%	38	3	-	41	9.0%
4	Хөрөнгийн даатгал /ипотек/	15	7.4%	11	4.3%	36	2	-	38	8.4%
5	Хариуцлагын даатгал	9	4.5%	5	1.9%	7	2	-	9	2.0%
6	Зээлийн даатгал	4	2.0%	4	1.5%	12	-	-	12	2.6%
7	Санхүүгийн даатгал	2	1.0%	2	0.8%	1	-	-	1	0.2%
8	Ачаа, тээврийн даатгал	-	-	6	2.3%	2	-	-	2	0.5%
9	Даатгалын хохирлын үнэлгээ болон бусад	20	10%	28	11.0%	26	-	5	31	6.8%
	Нийт	201	100%	257	100%	350	98	5	453	100%

Ирсэн өргөдөл, гомдлын агуулгаас үзэхэд, даатгуулагч даатгалын тохиолдол гарсан үед тухайн тохиолдлыг нотлох, даатгагч, эрх бүхий байгууллагад мэдэгдэх зэрэг үүргээ биелүүлээгүй, даатгалын хураамжийг хуваарьт заасан хугацаанд нь төлөөгүй зэргээс үүдэн даатгалын нөхөн төлбөр авах боломжгүй байдал үүсдэг байна.

Мөн даатгагчийн зүгээс иргэдийн мэдлэг мэдээлэл дутмаг байдлыг ашиглан үндэслэлгүйгээр нөхөн төлбөрийг хасаж олгосон, даатгалын нөхөн төлбөр олгохдоо хууль

тогтоомж болон гэрээнд заагаагүй аливаа шаардлага, хязгаарлалт тавих, бүлгийн хэлбэртэй даатгалын гэрээ байгуулахдаа даатгуулагчид бүтээгдэхүүний талаар танилцуулга хийгээгүй, зөвшөөрөл авалгүйгээр гэрээ хийх, даатгуулагчид танилцуулаагүй гэрээний нөхцөлийг өөрчлөх, гэрээнд заасан эрсдэлийн дагуу даатгалын тохиолдолд үүсэж, гэрээнд нөхөн төлбөр олгохоор зохицуулагдсан байхад илт үндэслэлгүйгээр татгалзах, нөхөн төлбөр олгохгүй удаах, даатгуулагчдыг чирэгдүүлж, даатгалын гэрээнд даатгалын зүйлийн талаарх мэдээллийг зөрүүлж бичсэн зэрэг зөрчил дутагдал гаргасан байна.

Тайлант хугацаанд харилцагчийн хохирол барагдуулах талаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулан 207 иргэн, хуулийн этгээдэд 6,741,886,208.0 төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулахаар урьдчилан шийдвэрлэснээс, даатгагч 117 иргэн, хуулийн этгээдэд 3,744,412,806.0 төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон, түүнчлэн иргэдийн утсаар гаргасан гомдлын дагуу тухай бүр даатгалын компанитай холбогдож, 4 иргэний нийт 8,041,900.0 төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус олгуулсан байна.

### 1.1.3 Банк бус санхүүгийн байгууллага

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын үйл ажиллагаатай холбоотой нийт 274 өргөдөл, гомдол ирүүлснээс албан бичгээр хандсан 131, цахим системээр хандсан 24, Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан ирүүлсэн 8, утсаар хандсан 102 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн бол албан бичгээр ирсэн 9 өргөдөл, гомдол хуулийн хугацаанд хянагдаж байна.

Өргөдөл, гомдлыг товч утгаар нь ангилбал:

Хүснэгт 5. ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой албан бичгээр ирсэн өргөдлийн товч утга

№	Товч утга	2021	Эзлэх хувь	2022	Эзлэх хувь	2023				
						Албан бичиг	Цахим, /info/	11-11 төв	Нийт	Эзлэх хувь
1	Зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл	40	47.6%	46	32.8%	46	11	2	59	34.3%
2	Зээл болон хүүгийн тооцоолол	7	8.3%	23	16.4%	8	1	1	10	5.8%
3	Барьцааны зүйл чөлөөлүүлэх	2	2.4%	10	7.1%	1	-	-	1	0.6%
4	Зээлийн гэрээний маргаан	4	4.8%	1	0.7%	10	-	-	10	5.8%
5	ББСБ-ын үйл ажиллагаа	20	23.8%	19	13.5%	52	5	1	58	33.7%
6	Лавлагаа	5	6.0%	5	3.5%	12	-	-	12	7.0%
7	Бусад <sup>2</sup>	6	7.1%	36	26%	11	7	4	22	12.8%
	Нийт	84	100%	140	100%	140	24	8	172	100%

<sup>2</sup> Нотлох баримт гаргуулах тухай хүсэлт

Ирүүлсэн өргөдөл, гомдлын 33.7 хувийг ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой, 34.3 хувийг зээлийн мэдээллийн сантай холбоотой өргөдөл, гомдол тус тус эзэлж байна.

График 7. ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн харьцуулалт





График 8. ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн хэлбэр



Ирүүлсэн өргөдөл, гомдлын дийлэнх хувийг хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа болон шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэрэгтэй холбоотой өргөдөл, гомдол эзэлж байна.

Зээлийн мэдээллийн сангийн мэдээлэлтэй холбоотой гомдлын хувьд иргэд зээлээ төлөөгүй хугацаа хэтрүүлсэн, өөрсдийн мэдлэг, мэдээлэл дутмаг байдлаас зээл хойшлуулах хүсэлтээ тухайн ББСБ-д албан ёсоор хүргүүлээгүйн улмаас маргаан үүсэх, улмаар зээлийн мэдээллийн сан дахь зээлийн ангилал буурч бүртгэгдэх тохиолдлууд гарсаар байна. Мөн дээрх байдал нь иргэдийн авсан зээлийн чанар муудахад нөлөөлсөн байна.

Тайлант хугацаанд иргэдийн хохирлыг барагдуулах чиглэлээр нэр бүхий 2 ББСБ-д иргэний зээлийн мэдээллийн сан дахь мэдээллийг засуулах тухай үүрэг өгсөн, 1 иргэний барьцаа хөрөнгийг чөлөөлүүлсэн, зээл болон хүүгийн тооцооллын талаар зөвлөгөө, мэдээлэл хүргүүлсэн, ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн дагуу нэр бүхий 6 ББСБ-д мэдэгдэл хүргүүлсэн, мөн иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу нэр бүхий 6 ББСБ-ийн үйл ажиллагаанд Зөрчлийн тухай хуулийн дагуу хэрэг бүртгэлтийн хэрэг нээгдсэн байна.


### 1.1.4 Хадгаламж, зээлийн хоршоо

Тайлант хугацаанд хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-дын үйл ажиллагаатай холбогдуулан нийт 18 өргөдөл, гомдол ирүүлснээс албан бичгээр хандсан 14, утсаар хандсан 4 гомдлыг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 6. ХЗХ-дын үйл ажиллагаатай холбоотой албан бичгээр ирсэн өргөдлийн товч утга

№	Товч утга	2021	Эзлэх хувь	2022	Эзлэх хувь	2023				
						Албан бичиг	Цахим	11-11 төв	Нийт	Эзлэх хувь
1	Лавлагаа гаргуулах	3	14.0%	3	16.7%	5	-		5	35.7%
2	Хадгаламж буцаан олгоогүй	1	5.0%	7	27.8%	-	-	-	-	-
3	ХЗХ-дын үйл ажиллагаа	7	33.0%	4	22.2%	1	3	-	4	28.6%
4	Бусад	10	48.0%	6	33.3%	4	1	-	5	35.7%
	Нийт	21	100%	20	100%	10	4	-	14	100%

График 9. ХЗХ-дын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн харьцуулалт




### 1.1.5. Бусад

Хүснэгт 7. Бусад өргөдлийн товч утга

№	Төрөл	2023			
		Албан бичгээр	Цахим	11-11 төв	Нийт
1	Хорооны хяналттай холбоотой	3	6	2	11
2	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа	9	2	-	11
3	Зохицуулалтын бус	8	17	-	25
4	Виртуал хөрөнгө	-	6	-	6
5	Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх	-	1	-	1
6	Зөрчлийн болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой	11	-	-	11
7	Бусад /хүсэлт/	2	-	2	4
	Нийт	33	32	4	69

График 11. Бусад өргөдөл



### ХОЁР. АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БУСАД АРГА ХЭМЖЭЭ

1. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр цахим мэдээллийн хэрэгслээр явж буй зар сурталчилгаанд хяналт тавих чиг үүргийн дагуу цахим хуудсуудаар гарч буй мэдээлэлтэй танилцаж, зөрчил гаргасан байж болзошгүй болон зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээдтэй холбогдуулан хууль тогтоомжийн дагуу тухай бүр зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.
2. Орон нутаг дахь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч болон бусад шалтгааны улмаас өөрийн биеэр ирэх боломжгүй иргэдэд зориулж Хорооны цахим хуудас /цахим болон инфо/ <http://www.frc.mn/i/Feedback/>-аар дамжуулан өргөдөл, гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэж байна.
3. Ирүүлсэн нийт өргөдөл, гомдлын бүртгэлийг зохицуулалтын салбар тус бүрээр тогтмол хөтөлж, мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна.

--o0o--